

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/75/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот

2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Мөнхтулга

Утас: 70432545

цахим хаяг: munkhtulga.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2022.01.26 № 111  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА  
Э.ДӨЛБАДРАЛ ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДВААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>24,415,551.00</b>	<b>18,307,298.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	4,425,000.00	274,500.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	4,000,000.00	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	425,000.00	274,500.00
3351	Байгууллагаас авах авлага	425,000.00	274,500.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	19,990,551.00	18,032,798.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,707,350.00	2,197,410.00
35110	Тусгай зориулалттай материал	1,707,350.00	2,197,410.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	18,283,201.00	15,835,388.00
35410	Бичиг хэргийн материал	4,327,336.00	2,816,912.00
35420	Аж ахуйн материал	12,194,565.00	11,257,176.00
35470	Бусад хангамжийн материал	1,761,300.00	1,761,300.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>999,212,260.34</b>	<b>965,919,527.53</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	999,212,260.34	965,919,527.53
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	941,282,927.20	908,019,527.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	814,830,700.00	814,830,700.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-31,954,145.04	-47,931,217.56
39203	Авто-тээврийн хэрэгсэл	113,789,800.00	113,789,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-22,337,188.89	-41,302,155.57
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	392,790,601.76	407,872,127.76
39206	Хуримтлагдсан элэгдэл	-346,087,954.48	-363,611,934.03
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,535,520.86	29,335,670.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,110,901.40	-19,419,583.82
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,860,576.80	18,610,576.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,034,082.41	-4,154,456.91
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	57,929,333.14	57,900,000.00
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-850,666.86	-880,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	57,900,000.00	57,900,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,023,627,811.34</b>	<b>984,226,825.53</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,023,627,811.34</b>	<b>984,226,825.53</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,023,627,811.34	984,226,825.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	254,822,164.94	254,822,164.94
51101	Өмч: - төрийн	254,822,164.94	254,822,164.94
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	767,502,056.43	728,243,631.75
51210	Өмнөх үеийн үр дүн	767,502,056.43	767,644,617.56
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-39,400,985.81
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,303,589.97	1,161,028.84
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,023,627,811.34</b>	<b>984,226,825.53</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>878,330,693.67</b>	<b>823,377,641.38</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>179,333,247.00</b>	<b>67,252,091.38</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	179,333,247.00	67,252,091.38
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	179,333,247.00	67,252,091.38
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	168,927,047.00	55,769,823.38
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,146,200.00	7,692,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,260,000.00	3,789,868.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>195,154,146.67</b>	<b>275,508,250.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	503,843,300.00	480,617,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	151,706,760.00	233,614,150.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	24,607,000.00	10,150,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	127,099,760.00	223,464,150.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	39,331,600.00	39,331,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,331,600.00	39,331,600.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	4,115,786.67	2,562,500.00
133003	Хөрөнгийн	4,115,786.67	2,562,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>943,531,118.80</b>	<b>862,778,627.19</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>943,531,118.80</b>	<b>862,778,627.19</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	691,276,476.80	667,496,813.81
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	384,520,123.00	389,266,093.00
210101	Үндсэн цалин	384,520,123.00	389,266,093.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	48,126,016.00	50,376,692.00
210201	Тэтгэврийн даатгал	33,261,918.00	35,338,068.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,808,047.00	3,892,659.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,046,437.00	3,114,128.00
210204	Ажилгүйдлийн даатгал	728,148.00	730,167.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,281,466.00	7,301,670.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	39,290,900.00	38,601,134.00
210302	Түлш, халаалт	33,160,050.00	33,160,050.00
210303	Цэвэр, бохир ус	5,630,850.00	5,441,084.00
210304	Байрны түрээс	500,000.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	40,154,429.67	37,175,024.00
210401	Бичиг хэрэг	13,670,639.67	9,444,292.00
210402	Тээвэр, шатахуун	20,757,430.00	16,107,753.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	330,900.00	211,200.00
210404	Ном, хэвлэл	2,641,810.00	2,008,440.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,753,650.00	3,249,726.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	6,153,613.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	870,000.00	1,220,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	870,000.00	1,220,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,739,000.00	3,195,000.00
210604	Урсгал засвар	3,739,000.00	3,195,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	13,490,300.00	14,444,600.00
210702	Дотоод албан томилолт	13,490,300.00	14,444,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	24,554,800.00	23,249,420.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,076,600.00	22,818,820.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	37,600.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	430,600.00	430,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,010,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	136,530,908.13	109,968,550.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,679,377.00	38,891,950.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	81,851,531.13	71,076,600.81
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	252,254,642.00	195,281,813.38
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	16,882,300.00	1,300,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,827,000.00	1,300,000.00

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,055,300.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>4,575,400.00</b>	<b>00.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,575,400.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>52,428,060.00</b>	<b>106,453,840.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,428,060.00	106,453,840.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>178,368,882.00</b>	<b>87,527,973.38</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	178,368,882.00	63,612,723.38
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	23,915,250.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-65,200,425.13</b>	<b>-39,400,985.81</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>154,973.33</b>	<b>00.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	154,973.33	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-154,973.33</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-65,355,398.46</b>	<b>-39,400,985.81</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,822,164.94	1,303,589.97	832,918,454.89	1,089,044,209.80
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>254,822,164.94</b>	<b>1,303,589.97</b>	<b>832,918,454.89</b>	1,089,044,209.80
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-65,355,398.46	-65,355,398.46
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>254,822,164.94</b>	<b>1,303,589.97</b>	<b>767,502,056.43</b>	1,023,627,811.34
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>254,822,164.94</b>	<b>1,303,589.97</b>	<b>767,502,056.43</b>	1,023,627,811.34
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	142,561.13	142,561.13
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>254,822,164.94</b>	<b>1,303,589.97</b>	<b>767,644,617.56</b>	1,023,770,372.47
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-142,561.13	00.00	-142,561.13
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-39,400,985.81	-39,400,985.81
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>254,822,164.94</b>	<b>1,161,028.84</b>	<b>728,243,631.75</b>	984,226,825.53

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>886,228,443.00</b>	<b>825,268,013.38</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>178,243,232.00</b>	<b>63,612,723.38</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	178,243,232.00	63,612,723.38
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	178,243,232.00	63,612,723.38
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	169,206,232.00	55,769,823.38
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,037,000.00	7,842,900.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>707,985,211.00</b>	<b>761,655,290.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	503,843,300.00	480,617,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>164,695,522.00</b>	<b>241,706,390.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	37,595,762.00	18,242,240.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	127,099,760.00	223,464,150.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>39,331,600.00</b>	<b>39,331,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,331,600.00	39,331,600.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>114,789.00</b>	<b>00.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	114,789.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>870,812,442.00</b>	<b>791,274,013.38</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>870,812,442.00</b>	<b>791,274,013.38</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>618,430,011.00</b>	<b>595,052,200.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>381,158,600.00</b>	<b>389,264,716.00</b>
210101	Үндсэн цалин	293,309,700.00	289,900,814.00
210102	Нэмэгдэл	58,852,100.00	62,497,657.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,170,600.00	7,777,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,826,200.00	29,089,245.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>51,327,610.00</b>	<b>50,378,020.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	36,598,810.00	35,649,120.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,682,200.00	3,682,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,945,800.00	2,945,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	736,500.00	736,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,364,300.00	7,364,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>39,140,900.00</b>	<b>39,140,900.00</b>
210302	Түлш, халаалт	33,160,050.00	33,160,050.00
210303	Цэвэр, бохир ус	5,480,850.00	5,980,850.00
210304	Байрны түрээс	500,000.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>28,954,390.00</b>	<b>18,763,663.00</b>
210401	Бичиг хэрэг	5,409,000.00	4,196,800.00
210402	Тээвэр, шатахуун	19,968,790.00	12,073,963.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	330,900.00	211,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,245,700.00	2,281,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>396,000.00</b>	<b>2,276,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396,000.00	2,276,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>190,700.00</b>	<b>1,390,700.00</b>
210604	Урсгал засвар	190,700.00	1,390,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>13,490,300.00</b>	<b>14,444,600.00</b>
210702	Дотоод албан томилолт	13,490,300.00	14,444,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>37,655,562.00</b>	<b>27,379,260.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,188,600.00	22,818,820.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	37,600.00	37,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	430,600.00	430,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	13,998,762.00	4,092,240.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>62,115,949.00</b>	<b>52,014,341.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,115,949.00	52,014,341.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>252,382,431.00</b>	<b>196,221,813.38</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>17,010,089.00</b>	<b>2,240,000.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	114,789.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,840,000.00	2,240,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,055,300.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>4,575,400.00</b>	<b>00.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,575,400.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>52,428,060.00</b>	<b>106,453,840.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,428,060.00	106,453,840.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>178,368,882.00</b>	<b>87,527,973.38</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	178,368,882.00	63,612,723.38
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	23,915,250.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	15,416,001.00	33,994,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	15,541,651.00	33,994,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,541,651.00	33,994,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,541,651.00	33,994,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,541,651.00	33,994,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-15,541,651.00	-33,994,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-125,650.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	125,650.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	529,909,000.00	519,948,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	529,909,000.00	519,948,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	527,669,000.00	517,708,900.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	368,219,600.00	374,731,160.00
210101	Үндсэн цалин	278,864,600.00	285,376,160.00
210102	Нэмэгдэл	58,852,100.00	61,245,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,170,600.00	7,777,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,332,300.00	20,332,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,709,700.00	49,709,700.00
210201	Тэтгэврийн даатгал	34,980,800.00	34,980,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,682,200.00	3,682,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,945,800.00	2,945,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	736,500.00	736,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,364,400.00	7,364,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,140,900.00	39,140,900.00
210301	Гэрэл, цахилгаан	4,001,500.00	00.00
210302	Түлш, халаалт	29,781,500.00	33,160,050.00
210303	Цэвэр, бохир ус	5,357,900.00	5,980,850.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,432,200.00	9,400,200.00
210401	Бичиг хэрэг	5,409,000.00	3,356,800.00
210402	Тээвэр, шатахуун	9,307,200.00	5,041,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	361,000.00	211,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,355,000.00	790,800.00
2105	Нормативт зардал	396,000.00	396,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396,000.00	396,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	190,700.00	190,700.00
210604	Урсгал засвар	190,700.00	190,700.00
2107	Томилолт, зочны зардал	17,372,700.00	14,444,600.00
210702	Дотоод албан томилолт	17,372,700.00	14,444,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	468,200.00	468,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	37,600.00	37,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	430,600.00	430,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35739000.00	29227440.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,739,000.00	29,227,440.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2240000.00	2240000.00

<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,240,000.00	2,240,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,240,000.00	2,240,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	529,909,000.00	519,948,900.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	490,577,400.00	480,617,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	490,577,400.00	480,617,300.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	39,331,600.00	39,331,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	39,331,600.00	39,331,600.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	520.00	58,301.00
620001	Удирдах ажилтан	38	38
620002	Гүйцэтгэх ажилтан	32	31
620003	Үйлчлэх ажилтан	2	2
620004	Гэрээт ажилтан	3	4

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>164,810,311.00</b>	<b>241,706,390.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>164,810,311.00</b>	<b>241,706,390.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	108,667,462.00	111,337,300.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	12,939,000.00	14,533,556.00
210101	Үндсэн цалин	12,939,000.00	4,524,654.00
210102	Нэмэгдэл		1,251,957.00
210105	Гэрээт ажлын хөлс		8,756,945.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	1,617,910.00	668,320.00
210201	Тэтгэврийн даатгал	1,617,910.00	668,320.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,341,690.00	9,363,463.00
210401	Бичиг хэрэг		840,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,450,990.00	7,032,563.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,890,700.00	1,490,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>		1,880,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		1,880,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	693,000.00	-
210702	Дотоод албан томилолт	693,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	41,187,362.00	26,911,060.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,188,600.00	22,818,820.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	17,998,762.00	4,092,240.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	41,888,500.00	56,780,901.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,888,500.00	56,780,901.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	56,142,849.00	130,369,090.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	56,142,849.00	130,369,090.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	114,789.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,600,000.00	-
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	52,428,060.00	106,453,840.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		23,915,250.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	164,810,311.00	241,706,390.00

<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	164,810,311.00	241,706,390.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	37,710,551.00	18,242,240.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	127,099,760.00	223,464,150.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Д.Мөнхтулга 2022 оны 01 дүгээр сарын 21-нээс 2021 оны 01 дугаар сарын 26-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 19-ны өдрийн 23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь “Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд барилга хот байгуулалтын болон газрын талаар төрөөс баримтлах бодлого газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх аймгийн эдийн засаг нийгмийн зорилтыг хот байгуулалт, төлөвлөлтийн бодлоготой уялдуулан хотын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах газрын кадастр эрхлэх мэдээллийн сан байгуулж иргэдэд мэдээллээр үйлчлэхэд оршино” гэсэн зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- *Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд барилга, хот байгуулалт болон газрын харилцааны талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэлийн төрөл бүрийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах ажлыг орон нутагт зохион байгуулах, газрын кадастрын мэдээллийн сан эрхлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэдээллээр ханган ажиллах*
- *Засгийн газрын шийдвэр болон харьяалах дээд шатны шийдвэрийг гүйцэтгэлийг хянах*
- *Харьяа яамны сайдын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Барилга хот байгуулалтын яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 822,627.6 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 8,222.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,755.8 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 39,401.0 мянган төгрөгөөр буюу 3.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 274.5 мянган төгрөг болж 4,150.5 мянган төгрөгөөр буюу нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлсэн авлага барагдсантай холбоотойгоор буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 18,032.8 мянган төгрөг болж 1,957.8 мянган төгрөгөөр буюу бараа материалыг акталсантай холбоотой буурсан байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 48,702.2 мянган төгрөг, үнэ төлбөргүйгээр 2,562.5 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 47,068.8 мянган төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 18,032.8 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 999,212.2 мянган төгрөг, оны эцэст 965,919.5 мянган төгрөг болж 33,292.7 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдэл, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 21,152.2 мянган төгрөгийн хөрөнгө актлах зөвшөөрөл олгосонтой холбоотой байна.

Тайлант онд 33,994.9 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 3,039.7 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 21,152.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан ба тайлант оны эцэст 1,442,468.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 1,023,627.8 мянган төгрөг байсан оны эцэст 984,226.8 мянган төгрөг болж тайлант онд 39,401.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 727,493.6 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 529,909.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 529,909.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 529,909.0 мянган төгрөгөөр батлан ирүүлжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 529,909.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 490,577.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 39,331.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 480,617.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 39,331.6 мянган төгрөг нийт 519,948.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 519,948.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 519,948.9 мянган төгрөг буюу 98.1 хувьтай байгаа нь Хангамж бараа материалын зардлыг 7,032.0 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 2,928.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 6,511.6 мянган төгрөгөөр хэмнэж цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 6,511.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт тайлангийн тайлангаар газрын дуудлага худалдаагаар 110,546.1 мянган төгрөг, түрээсийн орлогоор 6,150.0 мянган төгрөг, техник хяналтын орлого 117,010.3 мянган төгрөг, бэлчээр ашиглалтын холбооноос 8,000.0 мянган төгрөг нийт 241,706.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 217,791.1 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж 23,915.3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АДБОУС 701.8-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 139 мэдээллийг хугацаандаа оруулсан, 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 12 ажил гүйлгээг шилэн дансны сайтад байршуулаагүй байсныг аудитын явцад залрууллаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3,883.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг бүрэн хэрэгжүүлж, 75,608.2 мянган төгрөгийн 3 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж 5,215.5 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 100 хувь хэрэгжүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,072.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 750.0 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 1,322.5 мянган төгрөгийн 1 алдаа зөрчилд төлбөрийн акт бичигдлээ.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Орлого үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгээгүйтэй холбоотой 750.0 мянган төгрөг

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 750.0 мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлж санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

2. Шилэн дансны тухай хуулийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”-ийг 7 хоногийн дотор мэдээлнэ гэсэн заалтыг зөрчин төсвийн санхүүжилтийн орлогыг мэдээлээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь** Байгууллагын шилэн дансны сайтад 12 сарын төсвийн санхүүжилтийг нөхөж мэдээлүүлсэн.

### 4.2 Төлбөрийн акт

1. Гурвалжин холбоо хоршоотой гэрээ байгуулж гэрээгээр харуул хамгаалалтын үйлчилгээ авахдаа гэрээний үнээс 512.5 мянган төгрөгийг илүү олгоод авлагаар бүртгээгүй, байгууллагын үйл ажиллагаанд зарцуулагдаагүй бараа материалыг худалдан авсантай холбоотой 810.0 мянган төгрөг нийт 1322.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах” Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 5-р зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн хуулийн заалт, аудитын “Үнэн зөв байдал”, “Иж бүрэн” байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоов.

### 4.3 Зөвлөмж

Тус байгууллагад хийсэн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	3	2072.5	2	750.0	1	1,322.5	0	0	0	0

### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	3	2072.5	2	750.0	1	1,322.5	0	0	0	0

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:**

**Х.БОЛДБААТАР**

**АУДИТЫН МЕНЕЖЕР:**

**А.ЦЭЦЭГСҮРЭН**

**ТАЙЛАНГ БИНСЭН:**

**АХЛАХ АУДИТОР:**

**Д.МӨНХТУЛГА**